



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/22

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 279 дүгээр “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сумын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд зориулж 13,200,000 (арван гурван сая хоёр зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Өвс худалдан авахад зарцуулагдах 13,200,000 (арван гурван сая хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Нэмэлт санхүүжилтийн 100220355408 тоот данснаас гаргахыг нягтлан бодогч (Б.Түвшинжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Өвс худалдаж авах ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Мөнхзаяа)-д, санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Б.Түвшинжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



ДОТГОНЖАРГАЛ